



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 396

Улаанбаатар хот

“Монголын үнэт цаасны бирж” ХХК-ийн  
гүйцэтгэх захирлын албан тушаалд  
ажиллах зөвшөөрөл олгох тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын үнэт цаасны бирж” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд Сандуйжав овогтой Даваасамбууг томилохыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг “Монголын үнэт цаасны бирж” ХХК /С.Даваасамбуу/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА  З.НАРАНТУЯА

001054